

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны .... дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 276 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ,  
ТҮҮНД БАТЛАН ДААЛТ ГАРГАХ, ХҮҮГ НЬ НӨХӨН ТӨЛӨХ,  
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.4, 12.6, 12.8.4, 12.9-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7-д заасан бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх бол холбогдох харилцааг мөн энэ журмын хүрээнд зохицуулна.

1.3. Энэ журмын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ нь хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийг өргөтгөх, ажлын байрыг шинээр бий болгох, хадгалах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1. “хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.8-д заасан иргэнийг ойлгоно;

1.4.2. “малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-т заасан иргэнийг;

1.4.3. “нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн” гэж Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2003 оны 182 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нөхөрлөл, компани, хоршоо, төрийн (орон нутгийн) өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”-д заасны дагуу нөхөрлөл, хоршоог бүртгүүлэхээр холбогдох материалаа бүртгэлийн байгууллагад мэдүүлсэн иргэдийн бүлгийн эрх бүхий төлөөлөгчийг;

1.4.4. “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.12-т заасан аж ахуйн нэгж, иргэнийг;

1.4.5. “гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн” гэж гадаад улсад суралцахаас бусад зорилгоор явж, урт хугацаанд ажиллаж, амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэнийг;

1.4.6. “жижиг зээл” гэж ажлын байр шинээр бий болгох, хадгалах, өргөтгөхөд шаардлагатай санхүүжилтийг тодорхой хугацаатай, хүүтэй, эргэн төлөх нөхцөлтэй олгох мөнгөн хөрөнгийг;

1.4.7. “багцын батлан даалт” гэж жижиг зээл олгох банкны шалгуур үзүүлэлтийг хангасан ч барьцаа хөрөнгийн дутагдалтай байгаа зээлдэгчид зээлийн тодорхой хэмжээнд тохирсон барьцаа хөрөнгийг батлан даахыг;

1.4.8. “санхүүгийн дэмжлэг” гэж барьцаагүй, хүүгүй, тодорхой хувийг эргэн төлөх нөхцөлтэй олгох мөнгөн хөрөнгийг.

### **Хоёр. Жижиг зээл олгох**

2.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн (цаашид “зээл хүсэгч”)-д жижиг зээлийг олгоно.

2.2. Зээл хүсэгч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан Өрийн мэдээллийн нэгдсэн сан, Монголбанкны Зээлийн мэдээллийн мэдээллийн сан, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сан болон Сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй этгээд байна.

2.3. Зээл хүсэгч жижиг зээл хүссэн өргөдлийг дараах бичиг баримт, төслийн хамт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. зээл хүссэн өргөдөл (батлагдсан загварын дагуу);

2.3.2. иргэний үнэмлэхний хуулбар, аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээний хуулбар;

2.3.3. Зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй талаарх тодорхойлолт;

2.3.4. төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

2.3.5. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй тухай тодорхойлолт;

2.3.6. засгийн газрын бусад тусгай сангаас зээлгүй талаарх тодорхойлолт;

2.3.7. барьцаалах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;

2.3.8. Ажлын байр нэмэгдүүлэх, хадгалах, үйл ажиллагаагаа өргөтгөх зорилго бүхий, доорх шаардлага хангасан төсөл:

2.3.8.1. хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;

2.3.8.2. ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломж болон үйл ажиллагаа явуулах ажлын байр, орчныг тооцсон байх;

2.3.8.3. төслийн хүрээнд орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхлэх, үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн байх;

2.3.8.4. зээлийн мөнгөн дүнгийн 40 болон түүнээс дээш хувьд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

2.3.8.5. төслийн хүрээнд байнгын ажлын байр бий болгож, цаашид хадгалах боломжтой байх;

2.3.8.6. Банкнаас тавигдах бусад зээлийн шалгуурыг хангасан байх.

2.4. Сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээл хүсэгчийн өргөдөл, бичиг баримт, төслийг аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажлын 3 хоногийн дотор цахимаар болон шуудангаар хүргүүлнэ.

2.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга зээл хүсэгчийн өргөдөл, төсөл, бичиг баримтын иж бүрдэл нь шаардлага хангасан эсэхэд урьдчилсан байдлаар дүгнэлт гаргах Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг байгуулна.

2.6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн байгууллага, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэгч банкны тухайн аймаг, дүүрэг дэх салбар, төрийн бус байгууллага болон иргэний төлөөлөл байна;

2.7. Дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сүүлийн 3 жилийн турш бичил бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон тухайн орон нутгийн иргэний төлөөллийг оролцуулна.

2.8. Ажлын хэсэг сард 2-оос доошгүй удаа хуралдан зээл хүсэгчийн өргөдөл болон холбогдох бичиг баримтыг судалж, энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд урьдчилсан байдлаар зээл олгох тухай дүгнэлтийг гарган аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

2.9. Ажлын хэсэг зээл хүсэгчийн хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх төслийн талаар биечлэн танилцуулах боломжийг бүрдүүлж, ажлын хэсгийн хуралдааны үйл явцыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

2.10. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга Ажлын хэсгийн дүгнэлт болон холбогдох бичиг баримтыг хүлээн авч, түүнийг банканд албан бичиг болон цахим шуудангаар даруй хүргүүлнэ.

2.11. Банк зээл хүсэгчийн өргөдөл, төсөл, бичиг баримтыг судалж, ажлын 10 хоногт багтаан зээл олгох эсэх талаар эцсийн шийдвэрийг гаргаж, зээлдэгчтэй зээлийн гэрээ байгуулна.

2.12. Банк нөхөрлөл, хоршоонд зээл олгохдоо энэхүү журмын 1.4.3-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэхийг шалгаж, шаардлага хангасан тохиолдолд зээл олгоно.

2.13. Банкнаас жижиг зээл олгох шийдвэр гарсны дараа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээлдэгчид ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах, санхүүгийн

боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулж, аж ахуйн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

2.14. Жижиг зээл дамжуулан зээлдүүлэх банкныг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

2.15. Жижиг зээл дамжуулан зээлдүүлэх банк дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.15.1. Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 12 сарын хугацаанд хангасан байх;

2.15.2. олгосон зээлийн эрсдэлийг бүрэн хариуцаж, дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгааг тухайн банкны Монголбанк дахь харилцах данснаас гаргасан байх;

2.15.3. жижиг зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс бага байх;

2.15.4. өмнө нь жижиг зээл дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан бол гэрээний үүргийн биелэлтийг хангалттай сайн биелүүлсэн байх;

2.15.5. энэ журмын 2.14-т заасан сонгон шалгаруулалтын үеэр тавьсан бусад шаардлагыг хангасан байх.

2.16. Жижиг зээл дамжуулан зээлдүүлэх банкинд тавих бусад шаардлага, түүнийг сонгон шалгаруулах удирдамж, банктай байгуулах гэрээний жишиг загвар, жижиг зээлийн санхүүжилтийг аймаг, дүүрэгт хуваарилах аргачлалыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.17. Сонгон шалгаруулалтад шалгарсан банктай Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллага 36 сарын хугацаатай гэрээ байгуулж, гэрээний дагуу үе шаттайгаар жижиг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг тухайн банканд байршуулна.

2.18. Гэрээнд зээлийн хөрөнгийг банкны дансанд байршуулах болон зээл олгох нөхцөл, зээлийн хөрөнгийн үлдэгдлийг эргүүлэн татах хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага зэргийг тодорхой заана.

2.19. Жижиг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг банканд байршуулах хугацааг зөвхөн байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас улсын хэмжээнд болон хэсэгчилсэн байдлаар онцгой байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд 12 хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

2.20. Энэ журмын 2.19-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг Улсын онцгой комисс, Засгийн газрын онцгой

байдлын зэрэгт шилжсэн шийдвэр, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн зөвлөмжийн дагуу шийдвэрлэнэ.

2.21. Жижиг зээлийг зээлдэгчид 36 хүртэл сарын хугацаатай олгох бөгөөд үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 6 хүртэл сар байж болно.

2.22. Жижиг зээлийн хэмжээ хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 хүртэл сая төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 15.0 хүртэл сая төгрөг, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 20.0 хүртэл сая төгрөг тус тус байна.

2.23. Зээлийн гэрээг зөрчсөн болон зээлээ төлж дууссан боловч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд зээлдэгчийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авах эрхийг 24 сарын хугацаагаар хязгаарлана.

2.24. Зээлийн гэрээг зөрчсөн болон зээлээ төлж дууссан боловч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон баримт, материалыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлнө.

2.25. Зээлийг ашиглалтын явцад зориулалтын бусаар ашигласан нь хяналт шалгалтаар тогтоогдсон тохиолдолд зээлийг үл маргах журмаар буцаан төлүүлж, учирсан хохирлыг барагдуулна.

### **Гурав. Жижиг зээлд батлан даалт гаргах**

3.1. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасны дагуу олгох жижиг зээлд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн багцын батлан даалт гаргаж болно.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.14-т заасны дагуу шалгарсан банктai “Багцын батлан даалтын гэрээ” байгуулж, жижиг зээлийн багцын батлан даалтын хөрөнгийг банканд байршуулна.

3.3. Жижиг зээлийн багцын батлан даалтын хөрөнгийн хэмжээ нь банкаар дамжуулан зээлдүүлэх жижиг зээлийн нийт эх үүсвэрийн 3 хүртэл хувьтай тэнцүү байна.

3.4. Жижиг зээлийн багцын батлан даалтын хөрөнгийн хувь хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл жил бүр тогтооно.

3.5. Жижиг зээлийн багцын батлан даалтын хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

3.5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

3.5.2. гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

3.5.3. бусад.

3.6. Банк нь “Багцын батлан даалтын гэрээ”-ний дагуу жижиг зээл авах шалгуур үзүүлэлтийг хангасан, 3-с доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж ажлын

байраа хадгалж байгаа ч барьцаа хөрөнгийн дутагдалтай зээлдэгчид зээлийн дүнгийн 30 хүртэл хувьд тохирсон барьцаа хөрөнгийг батлан дааж болно.

3.7. Жижиг зээлд багцын батлан даалт гаргах нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, батлан даалтын төлбөр төлөх, батлан даалтыг түдгэлзүүлэх, зогсоох, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг “Багцийн батлан даалтын гэрээ”-нд тусган хэрэгжүүлнэ.

3.8. “Багцын батлан даалтын гэрээ”-ний жишиг загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **Дөрөв. Зээлийн хүүг нөхөн төлөх**

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-д заасан ажил олоход хүндрэлтэй иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол хүүгийн нийт төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.

4.2. Энэ журмын 4.1-д заасан хүсэлтийг зээлдэгч холбогдох баримт бичгийн хамт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ.

4.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлдэгчийн хүсэлт, зээлийн гэрээ, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг банканд төлсөн баримт, энэ журмын 4.1-д заасан зориулалтыг нотлох бусад санхүүгийн баримтыг үндэслэн зээлийн хэвийн төлөлттэй зээлдэгчид жижиг зээлийн хүүгийн нөхөн төлбөрийг улирал тутам төлнө.

### **Тав. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх**

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дараах санхүүгийн дэмжлэг олгоно.

5.1.1. малгүй болон цөөн малтай малчинг малжуулах төсөлд 5.0 хүртэл сая төгрөг;

5.1.2. хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэний төсөлд 10.0 хүртэл сая төгрөг.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7-д заасны дагуу батлагдсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дараах санхүүгийн дэмжлэг олгоно.

5.2.1. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төсөлд 20.0 хүртэл сая төгрөг;

5.2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохируулгатай ажлын байр бий болгох ажил олгогчийн төсөлд 30.0 хүртэл сая төгрөг;

5.2.3. бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн ажлын байр бий болгох төсөлд 50.0 хүртэл сая төгрөг.

5.3. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт дараах нөхцөлтэй байна. Үүнд:

5.3.1. Энэ журмын 5.2.1-т заасан төсөлд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 100 хүртэл хувиар хөнгөлнө;

5.3.2. Энэ журмын 5.1.2-т заасан төслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн хэрэгжүүлэх бол төсөлд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 50 хүртэл хувиар хөнгөлнө;

5.3.3. Энэ журмын 5.3.1, 5.3.2-т зааснаас бусад төсөлд олгосон санхүүгийн дэмжлэг 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.

5.4. Энэ журмын 5.3-т заасан санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хувь хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл тогтоож, төсөл, хөтөлбөрт тусган батална.

5.5. Иргэн, аж ахуйн нэгж санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдлөө холбогдох төслийн хамт өөрийн харъяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Үүнд:

5.5.1. санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл;

5.5.2. иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн иргэний үнэмлэхний хуулбар, аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээний хуулбар;

5.5.3. холбогдох чиглэлээр боловсруулсан төсөл;

5.5.4. хүн амын зорилгод бүлгийн онцлогтой уялдуулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр баталсан хөтөлбөрийн хүрээнд шаардагдах бусад бичиг баримт.

5.6. Төслийн хүрээнд шинэ ажлын байр бий болгосон, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг хадгалсан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмтэй хэлбэрээр ажлын байрыг бий болгосон, шаардлага хангасан тохиолдолд энэ журмын 5.3.1-т заасан хөнгөлөлтийг олгох.

5.7. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ.

5.8. Эргэн төлөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа нь иргэнд 36 хүртэл сар, аж ахуйн нэгжид 24 хүртэл сар байна.

5.9. Энэ журмын 5.3.1 заасан төсөл хэрэгжүүлэгчийн эргэн төлөлт 48 хүртэл сар байх бөгөөд иргэний хүсэлтийг харгалзан үзэж хуваарийг гаргаж тооцно.

5.10. Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан жижиг зээл авсан зээлдэгчид, 2.21-т заасан этгээдэд санхүүгийн дэмжлэг олгохгүй.

5.11. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаагүй, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй, хяналт шалгалт хийлгэхээс татгалзсан бол санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргүүлэн төлүүлнэ.

5.12. Энэхүү журмын 5.1, 5.2-т заасан этгээд гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан бол эргэн төлөлтийг төлж барагдуулснаас хойш 24 сарын дараа дахин санхүүгийн дэмжлэг авч болно.



- 5.13. Санхүүгийн дэмжлэгийг техник технологи ашиглан (fintech) автоматжуулж, орчин үеийн шинэлэг хэлбэрээр олгож болно.
- 5.14. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг санхүүгийн техник технологи ашиглан олгохдоо туршлага бүхий санхүүгийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 5.15. Санхүүгийн дэмжлэгийн шинэлэг хэлбэрийг хамтран зохион байгуулж, санхүүгийн дэмжлэгийг дамжуулан олгох байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.
- 5.16. Санхүүгийн дэмжлэг дамжуулан олгох санхүүгийн байгууллагад тавих шаардлага, түүнийг сонгон шалгаруулах удирдамж, хамтран ажиллах гэрээний жишиг загвар, санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийг аймаг, дүүрэгт хуваарилах аргачлалыг санхүү, төсвийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 5.17. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ажлын хэсэг, эсхүл хороо зохион байгуулах бөгөөд түүний бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг хууль тогтоомжид нийцүүлэн оролцуулна.
- 5.18. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаагүй, хуурамч тайлан мэдээ ирүүлсэн этгээдийг холбогдох хяналтын байгууллагаар шалгуулна.

### **Зургаа. Тайлагнал, ил тод байдал, хяналт**

- 6.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь олгосон жижиг зээл, батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн болон, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тухай мэдээллийг маягтын дагуу гаргаж, сар бүрийн 3-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийг нэгтгэн мөн сарын 10-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.2. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 6.1-д заасан мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулж, мэдээллийн сан үүсгэж олон нийтэд мэдээллэнэ.
- 6.3. Энэ журмын 6.1-д заасан мэдээллийн маягтын загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- 6.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт хийж, дүн мэдээг тухай бүр хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.5. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийн эх үүсвэрийн хэмжээ,

дамжуулан зээлдүүлэх банк болон зээлдэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой дүрэм, журам, удирдамж, бусад баримт бичиг, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалтыг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.

6.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон аймаг, дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд уг үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно.

6.7. Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна.

6.8. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан (ашигласан), гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол олгосон жижиг зээл, зээлийн хүү, санхүүгийн дэмжлэгийг буцаан төлүүлнэ.

6.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.10. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж нийтэд мэдээллэнэ.

---o0o---

## ТАНИЛЦУУЛГА

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7 дахь хэсэгт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.” гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан билээ.

Журмын зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.4, 12.6, 12.8.4, 12.9 дэх хэсэгт заасны дагуу малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд аж ахуй эрхлэхийг нь дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох, жижиг зээлийн хүүг нөхөн төлөх, жижиг зээлд батлан даалт гаргах болон инкубацийн үйлчилгээнд хамруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа болно.

Энэхүү журмын хүрээнд тус яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ажлын байр шинээр бий болгох, аж ахуй эрхлэлтийг дэмжих зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 10.0 хүртэл сая, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжид 20.0 хүртэл сая төгрөгийн жижиг зээлийг банкаар дамжуулан олгож, тэдгээрээс шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжийг жижиг зээлийн хүүг нөхөн төлөх, жижиг зээлд батлан даалт гаргах арга хэмжээнд хамруулж байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр батлан хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн хүрээнд дараах санхүүгийн дэмжлэгүүдийг олгож байна. Үүнд:

А. 35 ба түүнээс дээш насны иргэн, гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэнд аж ахуй эрхлэхэд зориулж 3 жилийн дотор эргэн төлөх нөхцөлтэйгээр 5.0 хүртэл сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг;

Б. 15-35 насны залуучуудад гарааны бизнес эрхлэхэд зориулж 3 жилийн дотор эргэн төлөх нөхцөлтэйгээр 10.0 сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг;

В. 15-45 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй ерхийг малжуулахад зориулж 3 жилийн дотор эргэн төлөх нөхцөлтэйгээр 4.0 болон 5.0 сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг;

Г. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд аж ахуй эрхлэхэд зориулж 4 жилийн дотор 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгээр 5.0 хүртэл сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг;

Д. Тэтгэврийн насны ахмадуудад аж ахуй эрхлэхэд зориулж 2 жилийн дотор эргэн төлөх нөхцөлтэйгээр 3.0 хүртэл сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг.

Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, халамжаас хөдөлмөр эрхлэлтрүү чиглэсэн бодлогын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх шаардлага үүсч байгаатай холбогдуулан журмыг шинэчлэн найруулсан болно.

Иймд дараах харилцааг зохицуулсан Засгийн газрын тогтоолын төслийг боловсрууллаа. Үүнд:

1. Монгол Улсын Их хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганаар хэлэлцэж баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай (Шинэчилсэн найруулга) хууль болон “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 87 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү журамд тодорхой өөрчлөлтүүдийг оруулсан.

Засгийн газрын тусгай сангийн тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 23.6 дахь хэсэгт заасны дагуу жижиг зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгж нь Өрийн мэдээллийн нэгдсэн санд зээлийн үлдэгдэлгүй, Зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өргүй этгээд байхыг;

Мөн хуулийн 24.6 дахь хэсэгт заасны дагуу шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, дамжуулан зээлдүүлэх банк болон зээлдэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой бүхийл мэдээлэл, материалын жагсаалтыг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилж байх;

Мөн хуулийн 25.5 дахь хэсэгт заасны дагуу дээр дурдсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдахыг хүссэн зорилтот бүлгийн иргэдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, эсхүл хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг заавал оролцуулах;

2. Энэхүү журмын 2 дахь хэсэгт жижиг зээл хүсэгчийн үүрэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, банканд тавигдах шаардлага, зээлийн хэмжээ, хугацааг тодорхой тусгасан болно.

3. Ажил үйлчилгээ явуулах зорилгоор ХЭДС-гаар дамжуулан жижиг зээл авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барьцаа хөрөнгөгүй нь улмаас хүссэн зээлээ авах боломжгүй тохиолдолд энэхүү журмаар зээлд батлан даалт гаргах асуудлыг шийдвэрлэн тусгаж байгаа нь давуу тал болж байна.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7 дахь хэсэгт заасны дагуу жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтоох хүрээнд уг

журамд иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн дээд хэмжээ, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, Мөн бичил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд ажлын байр бий болгох, нэмэгдүүлэхэд санхүүгийн дэмжлэг олгохоор болж байгаа. Энэ нь бичил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд цаашлаад Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх давуу тал болно.

5. Бичил бизнес эрхэлж, ажилтай, орлоготой болохоор зорьж байгаа иргэдэд санхүүгийн дэмжлэгийг уламжлалт хэлбэрээр олгохоос гадна техник, технологийн дэвшлийг ашиглан иргэдэд түргэн шуурхай олгох боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг шинээр тусгасан. Энэхүү зохицуулалтын дагуу санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа 1-2 өдөрт иргэдэд хүрэх, богино хугацааны санхүүгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн болно.

6. Байгалийн гамшиг, цар тахал, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн сөрөг үр дагаварыг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах асуудлыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн зөвлөмжийг дагуу шийдвэрлэж болохоор тусгасан.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар корона вируст халдварт цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдолд орсон, тасарсан, цалин, орлого нь тасалдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт хамрагдсан залуучууд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчид санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжид учирч болох эрсдлээс сэргийлэх зээлийн өрийн дарамтаас гарах, ингэснээр төлбөрийг тодорхой хугацаагаар хойшлуулах, үйл ажиллагаа нь тогворжих ажлын байраа хадгалах боломж нээгдэнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2020 онуудад жижиг зээлийг 5461 иргэнд 51,1 тэрбум төгрөгийг, санхүүгийн дэмжлэг авсан 24041 иргэнд 70,4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

7. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 1/1288 тоот, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг хүргүүлж бүх яамдаас санал авч байсан. Холбогдох яамдаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн энэхүү журамд тусган шинэчлэн найруулсан болно.

8. Журмыг шинэчлэн найруулснаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021, оны төсвийн багцад ямар нэг өөрчлөлт орохгүй бөгөөд батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагааг зохион байгуулах болно.